

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтсийн түүхэн замнал

БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1960 оны 4-р сарын 8-ны өдрийн 94-р зарлигаар тоо бүртгэлийн газрыг улсын төлөвлөгөөний комиссоос тусгаарлаж БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дэргэд улсын тоо бүртгэлийн төв газрыг байгуулсаны зэрэгцээ МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1960 оны 4-р сарын 7-ны өдрийн 99/167-р тогтоолоор аймаг хотод тоо бүртгэлийн товчоог байгуулж, сумдад тоо бүртгэлийн улсын байцаагчийг бий болгосон байна.

Аймгийн тоо бүртгэлийн товчоо нь анх байгуулагдахад даргаар нь А.Бөкей, ахлах мэргэжилтнээр С.Хавдслам, Матаа, Машай, Ахет, Нургаз, нарын мэргэжилтэнтэй бүгд 6 орон тоотойгоор ажиллаж байжээ.

Аймгийн тоо бүртгэлийн товчоо нь улсын тоо бүртгэлийн төв газрын коллегоор 1960 оны 10-р сард батлагдсан тоо бүртгэлийн товчооны дүрэм болон бүртгэл, статистикийн талаар гаргасан нам засгийн тогтоол, шийдвэрүүд, улсын тоо бүртгэлийн төв газраас гаргасан тушаал, заавар, нэгдсэн аргачлалыг үндэслэн ажлаа явуулж эхэлжээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1961 оны 12-р сарын 6-ны өдрийн 623-р тогтоолоор сумдын гүйцэтгэх захиргаадад орлогч даргын орон тоог бий болгож сумын төлөвлөгөө тоо бүртгэл, захиргааны төсөв, тэтгэвэр тусламж, татвар хураамжийн асуудлыг хариуцуулсан юм. Улмаар тоо бүртгэл гэдэг үгийн оронд дэлхий нийтээр хэрэглэж хэвшсэн "статистик" гэсэн нэр томъёо хэрэглэх нь тохиромжтой гэж үзээд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1964 оны 3-р сарын 6-ны өдрийн 111-р тогтоолоор тоо бүртгэлийн төв газрыг Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Статистикийн төв газар, аймаг хотын тоо бүртгэлийн товчоог аймаг, хотын статистикийн товчоо гэж нэрлэсэн байна.

Аймгийн статистикийн алба нь байгуулагдсан тэр өдрөөс эхлэн статистикийн төв газраас баталсан дүрэм заавар, чиглэл, аймгийн намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны өдөр тутмын удирдлагын дор аймгийн нутаг дэвсгэрт бүртгэл статистикийн ажлыг эрхлэн зохион байгуулан явуулж ирлээ. Энэ хугацаанд нам, засгаас авсан удаа дараагийн арга хэмжээ, нийгэм-эдийн засгийн хөгжилтэй уялдан аймгийн статистикийн алба зохион байгуулалтын хувьд бэхжиж, мэргэжилтэй боловсон хүчнээр хангагдсан төдийгүй, түүний гүйцэтгэх үүрэг, цар хэмжээ үлэмж өслөө. 1980-аад оны үед аймаг орны төлөвлөгөөт үзүүлэлтийн биелэлтийг 580 гаруй үзүүлэлтээр дүгнэж, аймгийн удирдах байгууллагадаа танилцуулж, хөдөлмөрчиддөө хэвлэл, радиогоор дамжуулан сурталчилан ажиллаж ирсэн. Статистикийн товчоо нь анх байгуулагдсан 1960-1965 оны үед бүртгэлийн техник ажиллагааг сампин, тооны гар ажиллагаатай фэликс, арифмометр зэрэг машиныг хэрэглэж, 1965 оноос цахилгаан машин, 1974 оноос Шарп Ел8-11-А, Шарп СР-225 маркийн электрон машинтай боллоо. Аймаг, хотоос статистикийн шуурхай тайлан мэдээг Т-63 маркийн телетайпаар дамжуулж байлаа. Аймгийн статистикийн алба шуурхай мэдээ, тайлан төлөвлөгөөний биелэлт гаргаад зогсохгүй эдийн засгийн албадтай хамтран судалгаа тооцоо боловсруулах, улс ардын аж ахуйн салбарт анхан шатны бүртгэл нэвтрүүлэх, бүртгэлээр социалист өмчинд тавих хяналтыг хүчтэй болгох, шуурхай мэдээ тайланг худал гаргаж, улсыг хуурч мэхлэхийн эсрэг тэмцэх, түүнд тогтмол хяналт тавих, хөдөлмөрчдийн эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх талаар ихээхэн ажил хийгдэж зохих үр дүнд хүрлээ.

Аймгийн статистикийн албаны хөгжилд статистикийн товчооны анхны дарга А.Бөкей, он удаан жил энэ албанд ажилласан Д.Хизат, О.Баатархүү, 1960 оноос уг албанд ажиллаж байсан Буянт сумын

орлогч дарга Г.Энхээ, мөн сумын орлогч даргаар олон жил идэвхи зүтгэл үр бүтээлтэй ажилласан Х.Онабас, Назихан, М.Аятхан, Хавкей, Д.Баасан, О.Баатархүү, Ж.Цэдэв, Х.Бахыт нар нь ихээхэн хувь нэмрээ оруулсан хүмүүс юм.

1990 оноос хойш улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр эдийн засаг, нийгмийн салбарт гүн гүнзгий өөрчлөлтүүд гарч, статистикийн албаны гүйцэтгэх үүрэг роль нь өөрчлөгдсөн.

1994 онд Улсын Их Хурал "Статистикийн тухай" хуулийг батлан гаргасанаар статистикийн албаны хууль эрх зүйн орчин бий болсон ба энэ хуулийнд 1997 онд нэмэлт өөрчлөлтүүд оруулж батлан гаргасанаар Монгол улсад албан ёсны статистикийн үйл ажиллагаа явуулдаг төв байгууллага Үндэсний Статистикийн газрыг Улсын Их Хурлын харьяа байгууллага болгон статусыг өөрчилж, аймаг нийслэлд Засаг даргын дэргэдэх Статистикийн хэлтсийг шинээр зохион байгуулсанаар түүхэн шинэ хуудас нэгдсэн юм.

Тус аймагт 1997 оны 8-р сард шинэ хэлтэс зохион байгуулагдан ажлаа эхэлсэн ба хэлтсийн даргаар Х.Бахыт томилогдож, ахлах мэргэжилтэнээр Х.Өмирзах, мэргэжилтэн Ж.Цэдэв, Х.Рыс, Ш.Манзелхан нарын бүрэлдэхүүнтэй ажилласан юм. Статистикийн хэлтэс нь албан ёсны статистикийн үйл ажиллагааг орон нутагт хэрэгжүүлэх, мэдээ, тайлан мэдээллийг боловсронгуй болгох, хамрах хүрээг өргөтгөх, энэ салбарт мэдээлэл холбооны технологийн ололт, дэвшилт техник технологи нэвтрүүлж, аймгийн Засаг даргын тамгын газарт компьютерийн дотоод сүлжээг өөрийн биеэр гардан зохион байгуулан хийж, интернэтийн сүлжээг аймагтаа анх ашиглалтанд оруулсан ба дотоод сүлжээнд БЭВ сайт хийх технологи, программ хангамжуудыг нэвтрүүлэн статистикийн мэдээллийн ажлыг механикжуулах, автоматжуулах ажилуудыг амжилттай хэрэгжүүлж ирлээ. Одоо статистикийн хэлтсийн ахлах мэргэжилтэнээр Х.Рыс, салбар хариуцсан мэргэжилтэнээр Ш.Манзелхан, Н.Манаргүл, М.Дина, гэрээт ажилтан Х.Аленхан, жолооч Б.Агарыс, Өрхөд суурилсан нийгэм эдийн засгийн судалгааны судлаачаар А.Гулсайраш, А.Ахметжан, Е.Рина нарын бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаагаа явуулж байна. Аймгийн статистикийн албанд ажил үйлсээрээ шалгарсан дадлага туршлагатай тэргүүний хүмүүс олон байгаагийн дотор ахлах мэргэжилтэн Х.Рыс, мэргэжилтэн Ш.Манзелхан, Н.Манаргүл, судлаач А.Гулсайраш, сумын статистикийн ажилтанаас Алтай сумын төрийн сангийн төлөөлөгч А.Авил, Буянт сумын төрийн сангийн төлөөлөгч Р.Самдан, Дэлүүн сумын төрийн сангийн төлөөлөгч С.Аманкелд нарын ажлын дадлага туршлагатай, бусдыгаа үлгэрлэн ажиллаж байгаа олон хүнийг нэрлэж болно.

Хүн ам орон сууцны 2000, 2010 онуудын хүн ам орон сууцны тооллогын ажлын бэлтгэлийг хангах, зохион байгуулан явуулах, тооллогын материалыг төв газарт тушаах, тооллогын үр дүнгийн материалуудыг сурталчлах, салбаруудын үзүүлэлтээр статистикийн олон жилийн динамик мэдээлэлийн сан байгуулах, Хөдөө аж ахуйн тооллого, Аж ахуйн нэгжийн тооллого, жил бүрийн аймгийн Дотоодын нийт бүтээгдэхүүнийг орон нутагт тооцох, Өрхийн орлого, зарлагын болон Ажиллах хүчний түүвэр судалгаануудыг орон нутагт амжилттай зохион байгуулан явуулж хэрэгжүүлэн ажилласан.

Тус хэлтэс нь ажлын ололт амжилтаар системийн байгууллагуудын дотроос 1999 оны ажлаараа нэгдүгээр байр, 2002 оны ажлаараа гуравдугаар байр эзэлж, хамт олон нь ҮСГ-ын "Өргөмжлөл", иж бүрэн Pentium-4 компьютерээр шагнагдаж, хэлтсийн дарга нь гадаад оронд суралцах, аялах эрхийн бичгээр шагнагдаж, ҮСГ-ын БНСУ-ын Статистикийн байгууллагатай байгуулсан хамтын ажиллагааны чиглэлээр тус улсад танилцах айлчлалаар явж ирсэн бөгөөд 2004 оны ажлаар гуравдугаар байр, 2006 оны ажлаар тэргүүн байр, 2007 оны ажлаар тавдугаар байр, 2009 оны ажлаар хоёрдугаар байр, 2010 оны ажлаар

салбарын хэмжээнд гуравдугаар байр, 2012 оны ажлаар тэргүүн байр, 2013 онд гуравдугаар байр эзэлж “Өргөмжлөл” мөнгөн шагналаар шагнагдаж хамт олны хөдөлмөр бүтээлийг үнэлүүлж нөр их өөрчлөлт, шинэчлэл хийж хэлтсийн нүүр царайг танигдахааргүй өөрчилж бие даасан байдлыг бэхжүүлэн ажилласан. Үндэсний Статистикийн Хорооноос салбарын хэмжээнд хэрэгжүүлсэн Монстат төслийг амжилттай хэрэгжүүлэн гадаад харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлсэний үр дүнд 2012 онд Бүгд найрамдах Герман улсын статистикийн байгууллагын тэргүүн туршлагыг очиж судалсан, 2013 онд Японы СИМФОНИКА байгууллагын урилгаар зочилж тус орны статистикийн байгууллагын үйл ажиллагаатай танилцах боломж олдсон. Улсын Их Хурлаас баталсан Статистикийн салбарыг дунд хугацаанд/2011-2015 онд/ хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг орон нутагт хангахын тулд аймгийн ИТХТ-ийн хуралдаанаар төлөвлөгөө батлуулан ажиллаж байна.

Хэлтсийн ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуультай уялдуулан зохион байгуулж, үндсэн үйл ажиллагааг бүтээгдэхүүнээр тооцох, хүн өдөрт хувиарлах, үр дүнг тооцох зэрэг шинэлэг зүйлийг өөрийн ажилд үлгэр жишээчээр нэвтрүүлэн хэрэгжүүлж байна. Тус хэлтэсээс гарч байгаа хэвлэмэл бүтээгдэхүүний өнгө үзэмж, дизайн, агуулгыг баяжуулан сар бүр гардаг аймгийн эдийн засаг, нийгмийн байдлын тухай статистикийн танилцуулга бюллетень, нугалбар, жилийн эмхэтгэл зэргийг өнгөт хэвлэлээр хэвлэж, интернэт дахь хэлтсийн портал бэв сайтад байршуулан хэрэглэгчидэд тархаах ажлыг хөнгөн шуурхай хийж хэрэгжүүлдэг болсон.

Хэлтсийн ажлыг төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн хуультай уялдуулан зохион байгуулж, үндсэн үйл ажиллагааг бүтээгдэхүүнээр тооцох, хүн өдөрт хувиарлах, үр дүнг тооцох зэрэг шинэлэг зүйлийг өөрийн ажилд үлгэр жишээчээр нэвтрүүлэн хэрэгжүүлж ажилласан. Монгол улсад Статистикийн алба үүсч хөгжсөний 90 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэн өнгөрүүлж, мэргэжилтэн Ш.Манзелхан “Алтангадас” одонгоор, аймгийн ИТХТ-ийн “Өргөмжлөл” шагналаар ахлах мэргэжилтэн Х.Рыс, Бугат сумын төрийн сангийн төлөөлөгч А.Гаукар, хэлтсийн жолооч Б.Агарыс, аймгийн Засаг даргын “Хүндэт жуух” бичгээр мэргэжилтэн Н.Манаргүл, Сагсай сумын төрийн сангийн төлөөлөгч Б.Саги, Буянт сумын төрийн сангийн төлөөлөгч Р.Самдан нар шагнагдав. Статистикийн албыг хөгжүүлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, ажиллагсадын ажиллах орчиныг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэгдсэн ажлуудыг дэс дараатай хэрэгжүүлэн ажиллаж, хэлтсийг статистикийн салбарын нэгдсэн сүлжээнд холбох, мэдээлэл цуглуулах, боловсруулах, тархаах үйл ажиллагаандаа мэдээлэл технологийн ололт дэвшлийг өргөнөөр ашиглаж, өндөр хурдны интернэт үйлчилгээ, программ хангамж, техник хэрэгсэлүүд болох Apple-ийн бүтээгдэхүүнүүд iPad таблет ашиглах, компьютер техник хэрэгсэлийг шинэчлэх, материаллаг баазыг бэхжүүлэх, ажиллагсадын ажиллах орчиныг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэгдсэн ажлуудыг дэс дараатай хэрэгжүүлэн ажиллаж байна. Статистикийн анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах чиглэлээр хүн ам, өрхийн мэдээллийн санг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний мэдээллийн сантай ижил болгох ажлыг үр дүнтэй хийж 11740 хүнийг мэдээллийг шинээр нэмж оруулсан. Хөдөө аж ахуйн салбарын анхдагч мэдээлэлд малчидын бэлтгэсэн хадлан, тариаланчдын тариалсан талбай, хураасан ургацыг өрх, аж ахуйн нэгж бүрээр оруулж мэдээллийн сантай болсон.